

**ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛ  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ  
(2022-2024)**

## **ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2022-2024**

*/Боловсрол, шинжлэх ухааны газрын хөгжлийн дунд хугацааны баримт бичиг/*

### **Агуулга**

#### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

1.1.Боловсрол, шинжлэх ухааны газрын үйл ажиллагааны шинжилгээ

- Боловсон хүчин, хүний нөөцийн байдал
- Гадаад дотоод орчны шинжилгээ

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, СТРАТЕГИ**

- 2.1. Боловсрол шинжлэх ухааны газрын мандат.
- 2.2. Боловсрол, шинжлэх ухааны газрын алсын хараа, эрхэм зорилго
- 2.3. Орчны шинжилгээ
- 2.4. Стратегийн зорилтууд
- 2.5. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

#### **Хавсралт:**

- 2.6. Стратеги төлөвлөлтийн тайлан
- 2.7. Стратеги төлөвлөгөөний хяналт, үнэлгээ

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

### **1.1. Боловсрол, шинжлэх ухааны газрын үйл ажиллагааны шинжилгээ боловсон хүчин, хүний нөөцийн байдал:**

Боловсрол, шинжлэх ухааны газар нь дарга, сургалтын бодлогын хэрэгжилт, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, боловсролын баримт бичиг олгох асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, судлагдахуун хариуцсан мэргэжилтэн -11, / Математик мэдээллийн технологи-1, Монгол хэл, бичиг, уран зохиол-1, Хими, биологи, эрүүл мэнд-1, Нийгмийн ухаан / Түүх, газарзүй, нийгэм судлал, иргэний ёс зүйн боловсрол/-1, Физик, дүрслэх урлаг, зураг зүй, технологи-1, Гадаад хэл-1, Хөгжим, биеийн тамир-1, сургуулийн өмнөх боловсрол-2, бага боловсрол-2/, хөрөнгө оруулалт-төсвийн гүйцэтгэл хариуцсан-1, хүүхдийн хөгжил хамгаалал-дотуур байр хариуцсан-1, шинжлэх ухаан, технологи, инноваци, дээд боловсрол, мэргэжлийн боловсролын сургалт, багшийн хөгжил, орчин хариуцсан-1, цахим технологи мэдээллийн сүлжээ хариуцсан-1, хоол үйлдвэрлэл, сургалтын орчин-1, нягтлан бодогч-1, архив, бичиг хэргийн ажилтан-1, нярав-1, жолооч-1, үйлчлэгч-1/ нийт 25 орон тоотой ажиллаж байна.

Дарга, мэргэжилтнүүдийн 66.7 хувь нь магистр, 33.3 хувь нь бакалаврын боловсролтой, тухайн албан тушаалдаа 1-23 жил ажиллаж байна.

Мэргэжилтэн бүр зөвхөн өөрийн мэргэжлийн судлагдахуун хариуцахгүй өөр мэргэжлийн судлагдахууныг давхар хариуцан ажиллаж байна. Иймээс мэргэжилтэн бүрийн хариуцан ажиллаж байгаа судлагдахууны багш нарын тоо харилцан адилгүй, тухайлбал СӨБ-547 /эрхлэгч, арга зүйч, багш/, бага ангийн сургалт хариуцсан мэргэжилтэн нийт 358 /багш, сургалтын менежер/-тэй харилцдаг бол бусад судлагдахуун хариуцсан мэргэжилтний хувьд 78-109 багштай харилцаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байдаг. Ажлын ачааллыг жигдрүүлэх зорилгоор байгууллагын дотоод, гадаад ажлыг нэмэлтээр хариуцуулан ажиллуулж байна.

БШУГ нь ажлын чиг үүргийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ЕБС-25, насан туршийн боловсрол төвийн-2, төрийн өмчийн цэцэрлэг 33, хувийн хэвшлийн цэцэрлэг 8, МУИС-ын Ховд дахь салбар сургууль, Хөгжил политехник коллеж 70 байгууллагыг мэргэжлийн болон захиргааны удирдлага арга зүйгээр ханган ажилладаг.

Байгууллагын ажлын үр дагавар нь харьяа байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, үр нөлөө нь Ховд аймгийн нийт иргэдийн боловсрол, соёлын хөгжлийн түвшингөөр хэмжигдэж байдаг.

**А. Гадаад орчны шинжилгээ**

Боломж, гарсан эерэг өөрчлөлт	Эрсдэл
<p><b>1. Эрх зүйн орчин:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхээр заасан.</li> <li>2. Боловсролын салбарын эрх зүйн орчинг шинэчлэн</li> <li>3. “Боловсролын тухай багц хууль”, “Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт”, “Боловсрол үндэсний хөтөлбөр” батлагдаж, эрх зүйн таатай орчин бүрдсэн.</li> <li>4. “Боловсролын газрын ажиллах үлгэрчилсэн журам” батлагдсан.</li> <li>5. ТА-ны төв зөвлөлөөс мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтыг баталж өгсөн.</li> <li>6. ТҮ-ний байгууллагын төсвийн захирагчийг тухайн сумын Засаг дарга баталдаг болсон.</li> <li>7. Орон нутгийн боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр “Чадварлаг багш, сурагч, оюутан, монгол хэл бичиг, Чанартай боловсрол дэд хөтөлбөрүүдийг хэлэлцүүлэн иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч батлуулан хэрэгжүүлж байна.</li> <li>8. ТЗ-ны ажилчид Гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил улирал сараар төлөвлөж, гүйцэтгэлийг хагас жил, бүтэн жилээр тайлагнадаг болсон</li> </ol>	<p>- Орон нутгийн удирдлагын ойлголт хандлага, дэмжлэг жигд биш Салбарын хууль журмуудад удирдлагын хэт төвлөрөл бий болж, өөрийн удирлагын байгууллагуудын үүрэг оролцоо сул болсон</p>
<p><b>2. Эдийн засгийн хүчин зүйл:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр болон дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд</li> <li>2. Орон нутгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт.</li> <li>3. “Дэлхийн зөн”, “НТБ” зэрэг олон улсын байгууллага</li> <li>4. ТББ, Иргэдийн дэмжлэг туслалцаа</li> <li>5. Эцэг эхийн дэмжлэг өссөн</li> </ol>	<p>- Боловсролд оруулах улсын болон орон нутгийн хөрөнгийн хэмжээ бага - Санхүүгийн бэрхшээлээс шалтгаалж мэргэжилтнүүдийн мэргэжил арга зүйг дээшлүүлэх ажил удаашралтай - Мэргэжилтнүүдийн цалин хөлс хангалтгүй</p>

<p>6. Аж ахуй нэгж байгууллагын хандив, дэмжлэг, тусламжийн нөөцтэй.</p> <p>7. Боловсрол соёл урлагийн газар нь бие даасан барилга байгууламжтай</p>	
<p><b>3. Нийгэм, соёлын хүчин зүйлс:</b></p> <p>1. Боловсролын нийгмийн бодлогын эрх зүйн орчин бүрдсэн</p> <p>2. Боловсролыг ойлгох хандах иргэдийн ойлголтод нааштай өөрчлөлт орсон</p> <p>3. Боловсролын газрыг бусад салбар, төрийн ба төрийн бус байгууллагууд тууштай дэмждэг болсон.</p> <p>4. “Олон нийтийн оролцоот сургууль” төслийн загвар аймаг болсон</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Манай аймгийн хүн амын механик өсөлт их байдаг нь боловсролын үйлчилгээнд тэгш хамруулахад хүндрэл учруулдаг.</li> <li>- Мэргэжилтнүүдийн нийгмийн хамгааллын асуудлыг / орон байр, эмчилгээ үйлчилгээ, тэтгэмж.../ шийдвэрлэхэд хүндрэлтэй</li> </ul>
<p><b>4.Технологийн хүчин зүйлс:</b></p> <p>1. Боловсролын салбарт технологийн шинэчлэл хийх эрх зүйн болон оюун санааны орчин бүрдсэн.</p> <p>2. Сургалтын агуулга, стандарт хөтөлбөр шинэчлэгдэж байна.</p> <p>3. Аймаг, бүс, улс хоорондын мэргэжлийн байгууллагуудын харилцаа өргөжсөн</p> <p>4. Орон нутгийн зүгээс тус салбарт дэмжлэг үзүүлж хамтран ажиллах арга хэлбэрт ахиц өөрчлөлт гарсан</p> <p>5. Ковик 19 өвчин гарсантай холбоотойгоор бүх аймаг, нийслэл, яамтай цахим уулзалтыг тогтмол хийж мэдээлэл хурдан шуурхай солилцдог болсон</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Орчны стандартыг сайжруулах шаардлагатай</li> <li>- Сүлжээний даац, хүчин чадал, хурд тааруу</li> <li>- Алслагдмал сум, багийн сургуулиудад шугам сүлжээний асуудал бэрхшээлтэй.</li> <li>- Эрдэм шинжилгээний бүтээлийн тоог олшруулах, судалгааны бүтээлийг эргэлтэнд оруулах</li> </ul>

**Б.Дотоод орчны шинжилгээ**

Давуу тал	Сул тал
<p><b>1.Төсөв, санхүү</b></p> <p>1. Улсын төвлөрсөн төсвийн санхүүжилт</p> <p>2. Дэд бүтэц сайн хөгжсөн</p> <p>3.ТЗ-ын ажилчдын ГТ-ний биелэлтийг улирлаар дүгнэж, урамшуулал олгодог болсон.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төсөвлөсөн төсөв дутуу ирдэг</li> <li>- Төсвийн төлөвлөгөө хийхэд үндсэн байгууллагын саналыг харгалздаггүй, дээрээс шууд боловсруулж, батлуулдаг</li> <li>- Төсвийн зүйл анги бүрээр шаардагдах төсвийг хангалттай олгодоггүй</li> </ul>
<p><b>2. Дотоод зохион байгуулалт</b></p> <p>1. Байгууллагын эрх зүйн орчин бүрдсэн</p> <p>2. Байгууллагын дотор хамтарч ажиллах эрх зүйн орчин бүрдсэн</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн хүрэлцээ хангамж муудаж байгаа</li> </ul>

<p>3. Хөдөлмөрлөх орчин нөхцөл сайн бүрдсэн 4. Байгууллагын уур амьсгал эерэг 5. Босоо, хэвтээ удирдлагын тогтолцооны харилцаа, уялдаа, холбоо сайн</p>	
<p><b>3. Үндсэн үйл ажиллагаа</b> 1. Цэцэрлэг, сургууль, боловсролын байгууллага, багш, сурагчдын дунд судалгаа, туршилт явуулж, үр дүнг тооцох, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх 2. Орон нутгийн засаг, захиргаа болон боловсролын байгууллагуудыг мэдээ, мэдээллээр хангах боломжтой</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгаа шинжилгээний ажлын хүрээ дутмаг</li> <li>- Мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд санхүүгийн боломж хязгаарлагдмал</li> </ul>
<p><b>4. Хүний нөөцийн зохион байгуулалт</b> 1. Багшлах боловсон хүчнээр бүрэн хангагдсан. 2. БГ-ын мэргэжилтнүүдийг ТАХ-ын дагуу сонгон шалгаруулж авдаг, 3. Тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх нөхцөл бүрдсэн</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжилтний цалин хөлс бага учир сул гарсан ажлын байрны шаардлага хангах ажилтан орох боломжгүй, шаардлага хангасан нь цалин бага учир ордоггүй</li> <li>- Мэргэжилтнүүдийг чадавхжуулах нэгдсэн бодлого тодорхой бус</li> <li>- Батлуулсан бүтэц орон тоогоор ажиллахад хүрэлцэхүйц төсөв батлагддаггүй.</li> <li>- Ажлын байрны шаардлага, хэрэгцээг харгалзаж, төлөвлөсөн төсвийг төв байгууллагаас баталдаггүй.</li> <li>- Сургалтын стандартын өөрчлөлтөөс сургууль, цэцэрлэгийн багшийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, шинэ арга зүйд суралцуулахад цаг их шаардаж байна.</li> </ul>

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, СТРАТЕГИ**

### **2.1 БАЙГУУЛЛАГЫН МАНДАТ**

Боловсрол, шинжлэх ухааны газар нь Боловсролын тухай хуульд заасан дараах чиг үүргийг гүйцэтгэнэ

2.1.1 Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;

2.1.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймгийн Засаг даргад санал болгох;

2.1.3 Багш, суралцагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

2.1.4 Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх;

2.1.5.Боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх;

2.1.6. Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох;

2.1.7 Орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

2.1.8 Төрийн бус өмчийн боловсрол, сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

2.1.9. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дүрэмт хувцасны нэгдсэн загварыг батлах.

2.1.10 Өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах

### **2.2.АЛСЫН ХАРАА**

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн хүний хөгжлийн эрэлт хэрэгцээг хангах арга зүй технологийг санаачлагч, бүтээгч, түгээгч байгууллага болно.

### **2.3.ЭРХЭМ ЗОРИЛГО**

Орон нутгийн боловсрол соёлын үйлчилгээний хэрэгцээг хангасан, чанартай үйлчилгээг бий болгох тасралтгүй хөгжих чадвартай мэргэшсэн мэргэжилтэн бүхий орон нутгийн хөгжлийг загварчлагч сургалт, судалгаа, арга зүйн төв байна.

## 2.4. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

2.4.1 Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан, орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны хөгжлийн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж боловсролын үйлчилгээний хүртээмж, олон нийтийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх

2.4.2 Багшийн хөгжлийг дэмжин багш нарыг мэргэшүүлэх, тэргүүний арга технологийг нэвтрүүлэх чадвартай мэргэжилтний нөөцийг бэхжүүлж, тасралтгүй хөгжлийг ханган ажиллах;

2.4.3 Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих төлөвлөгөөг орон нутгийн онцлогтой уялдуулан хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийн суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ

2.4.4 Сургалт хөгжлийн ээлтэй орчин бүрдүүлж, байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох.

2.4.5 Мэргэжлийн боловсрол олгох, ажил мэргэжлийн чиг баримжааг олгох шинжлэх ухааны салбарын үйлчилгээг сайжруулах, хөгжүүлэх

2.4.6 Санхүү, хөрөнгө оруулалтыг зохистой болгох, үр ашгийг дээшлүүлэх

## 2.5 СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Стратегийн зорилт 1** : Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан, орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны хөгжлийн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж боловсролын үйлчилгээний хүртээмж, олон нийтийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ:

- 1.1. Боловсрол, шинжлэх ухааны талаарх төрийн бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн онцлогтой уялдуулан зохион байгуулна.
- 1.2. Хүүхэд, хүний хөгжлийг хангах үүрэг чиглэл бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдааг сайжруулж, тогтвортой хөгжлийг хангах, жендерийн мэдрэмжтэй бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.3. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ, иргэдийн санал хүсэлтийг хурдан шуурхай шийдвэрлэх төв болон хөгжинө.
- 1.4. Чанарын менежментийн тогтолцоо – Шаардлага MNS ISO 9001 : 2016 стандартыг байгууллага болон салбарын байгууллагад нэвтрүүлэн хэрэгжүүлж ажиллана.
- 1.5. "Стандарттай Ховд хөтөлбөр"-ийг нэвтрүүлнэ

**Стратегийн зорилт 2** :Багшийн хөгжлийг дэмжин багш нарыг мэргэшүүлэх, тэргүүний арга технологийг нэвтрүүлэх чадвартай хүний нөөцийг бэхжүүлж, тасралтгүй хөгжлийг ханган ажиллах;

2.1 МУ-ын Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд аймгийн “Чадварлаг багш, сурагч, оюутан” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх



2.2. Мэргэжилтнүүдийн судалгаа, шинжилгээ хийх чадварыг хөгжүүлж, судалгаанд суурилсан сургалт хөгжлийн үйл ажиллагааг өргөжүүлнэ

2.3. Сургалтын дэвшилтэд технологийг судлагдахуун тус бүрээр туршин хэрэгжүүлж, тэргүүний арга зүй, технологийн цахим цахим сан бүрдүүлж, бусад багш нарт түгээн дэлгэрүүлж, алдаршуулах.

2.4. Ажиллагсдын ажлын үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн хамгааллын арга хэмжээг хуульд нийцүүлэн өргөжүүлнэ.

**Стратегийн зорилт 3** : Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих төлөвлөгөөг орон нутгийн онцлогтой уялдуулан хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийн суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ:

- 3.1. Тогтвортой хөгжлийн боловсрол орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 3.2. “Чадварлаг багш, оюутан, сурагч” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 3.3. “Монгол хэл, бичиг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 3.4. “Чанартай боловсрол” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 3.5. Сургуулийн өмнөх боловсрол, сургуулийн насны хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, дотуур байранд хүмүүжих бага бүлгийн хүүхдэд зориулсан халамж хөгжлийн үйлчилгээг өргөжүүлнэ.
- 3.6. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- 3.7. Үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа монгол хэл бичиг, тогтвортой хөгжил, үдийн хоол хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх

**Стратегийн зорилт 4** : Сургалт хөгжлийн ээлтэй орчин бүрдүүлж, байгууллагын үйл ажиллагааг шилэн болгох.

Хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ:

- 4.1. Мэргэжилтэн, багш ажиллагсдын харилцаа, ёс зүйг сайжруулж, нийгэм сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлнэ.
- 4.2. Хүүхдийн нас, хөгжилд нийцсэн сургууль цэцэрлэгийн орчны стандартыг мөрдүүлж боловсролд тэгш хамрагдах боломжийг бүрдүүлнэ.
- 4.3. Байгууллагын ажилчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулна.
- 4.4. Байгууллагын үйл ажиллагааг шилэн, илүү нээлттэй, шуурхай үйлчилгээтэй болгоно.

**Стратегийн зорилт 5** : Мэргэжлийн боловсрол олгох, ажил мэргэжлийн чиг баримжааг олгох, шинжлэх ухааны салбарын үйлчилгээг сайжруулах, хөгжүүлнэ.

- 5.1. Мэргэжлийн боловсрол, шинжлэх ухааны салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулах мэргэжлийн боловсрол, шинжлэх ухааны салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- 5.2. Аймгийн ажилгүй иргэдэд мэргэжлийн боловсрол олгоход чиглэсэн үйлчилгээг өргөжүүлэх, мэргэжлийн боловсрол олгох анги танхим тоног төхөөрөмжөөр хангана.

**Стратегийн зорилт 6** : Санхүү хөрөнгө оруулалтыг зохистой болгох үр ашгийг дээшлүүлэх

- 6.1. Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
- 6.2. Санхүүгийн нөөцийн удирдлага, төлөвлөлтийг сайжруулах
- 6.3. Санхүүгийн ил тод байдлыг бий болгон байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн хяналт, бүтээлч оролцоог нэмэгдүүлнэ.

**ГУРАВ. Стратеги төлөвлөгөөг дараах байдлаар зохион байгуулна.**

3.1 Салбарын болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж зохион байгуулна.

3.2. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх аймгийн үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг зохион байгуулна.

3.3. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлын агуулга, арга зүй, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Боловсрол, шинжлэх ухааны газар, аймаг, орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

3.4. Стратеги төлөвлөгөөний зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар нийт албан хаагчдыг мэдээллээр хангах ажлыг байгууллагын удирдлага хариуцна.

3.5. Байгууллагын удирдлага стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц (хүн, санхүү, техник)-ийг төлөвлөн бүрдүүлж, зохион байгуулна.

3.6. Стратеги төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, эрхзүйн орчин бүрдүүлэх, иргэд, иргэний нийгмийн байгууллага, төр болон төрийн бус байгууллагуудын оролцоо уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

3.7. Стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн мониторингийн судалгааг “иргэний нийгмийн төлөөлөл, төрийн бус байгууллага орон тооны бус хяналтын зөвлөл хамтран хэрэгжүүлнэ.



Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

5.3 ХАВСРА ЛТ/ТАЙЛ АНЗорил т	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Үр дүнгийн үзүүлэлт		Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	
		Хүрэх	Хүрсэн	Хүрэх	Хүрсэн
Зорилт1	1.1. Боловсрол соёлын талаарх төрийн бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн онцлогтой уялдуулан зохион байгуулна.	Боловсрол, соёлын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн, хэрэгжилт, үр дүн			
	1.2. Хүүхэд, хүний хөгжлийг хангах үүрэг чиглэл бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдааг сайжруулж, тогтвортой хөгжлийг хангах, жендерийн мэдрэмжтэй бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	“Олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэг”-ийн болзол хангасан сургууль, цэцэрлэгийн тоо		Түншлэлийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалт	
	1.3. Иргэдийн боловсролыг дэмжин иргэд олон нийтийн бүтээлч оролцоог нэмэгдүүлж нийгмийн эгэх харицулагыг бэхжүүлэх “Олон нийтийн оролцоот сургууль - хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	ОНОС-хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн		ОНОС-дэд хөтөлбөрт зарцуулсан зардалын хэмжээ	
	1.4 Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг нэг цонхны зарчмаар хэрэгжүүлж иргэдийн санал хүсэлтийг хурдан шуурхай шийдвэрлэх төв болон хөгжинө	Иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэсэн тоо			
	1.5. Салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, хүүхэд	Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийн үзүүлэлт			

Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

	төвтэй хөгжлийн загварыг хэрэгжүүлнэ.				
Зорилт 2	2.1 Хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, цахим сургалтыг хөгжүүлнэ.	Багш нарын хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй технологийн хөгжилд зориулсан сургалтын тоо, хамрагдсан багш нар чанар үр дүн			
	2.2 Багшийн хөжлийг дэмжих “Чадварлаг багш” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Чадварлаг багш хөтөлбөр хэрэгжилт зарцуулсан			
	2.3 Мэргэжилтнүүдийн судалгаа, шинжилгээ хийх чадварыг хөгжүүлж, судалгаанд суурилсан сургалт хөгжлийн үйл ажиллагааг өргөжүүлнэ	Судалгааны бүтээлийн тоо  Мэргэжлийн ур чадварын дээшлүүлэх чиглэлийн сургалтын тоо, хамрагдсан ажилчдын тоо, чанар		Ажиллагсдыг чадваржуулахад зарцуулсан зардлын хэмжээ  Амжилт, шинэ санаа санаачлагыг дэмжин, урамшуулсан зардлын хэмжээ	
	2.4 Сургалтын дэвшилтэд технологийг туршин хэрэгжүүлж, тэргүүний арга зүй, технологийн цахим сан бүрдүүлнэ.	Технологийн санд бүртгэгдсэн бүтээлийн тоо			
	2.5 Ажиллагсдын ажлын үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн хамгааллын арга хэмжээг хуульд нийцүүлэн	Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал			
Зорилт 3	3.1. Хүүхэд бүрийн авьяас чадварыг хөгжүүлэх орон нутгийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ. /номын гэгээ, авьяас, хүүхэд бүр цэцэрлэгт/	Номын гэгээ, авьяас, хүүхэд бүр цэцэрлэгт хөтөлбөрийн хэрэгжилт зарцуулсан зардлын			

Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

		хэмжээ			
	3.2. Эх хэлний чадварыг сайжруулах хөтөлбөрийг орон нутгийн онцлогтой уялдуулан хэрэгжүүлнэ.	Эх хэлний сургалт чанар дээшилнэ			
	3.3. Сургалтын стандартын хэрэгжилтийг хангаж “Би чадна” анги нийтийн олимпиад, уралдааныг зохион байгуулна.	Анги нийтийн олимпиадын тоо, чанар			
	3.4. Орон нутгийн онцлогт нийцүүлэн хүүхэд хөгжүүлэх судлагдахууны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.				
	3.5. Сургуулийн өмнөх боловсрол, сургуулийн насны хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, дотуур байранд хүмүүжих бага бүлгийн хүүхдэд зориулсан халамж хөгжлийн үйлчилгээг өргөжүүлнэ.	Боловсролын үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо			
Зорилт 4	4.1 Мэргэжилтэн, багш ажиллагсдын харилцаа, ёс зүйг сайжруулж, сургууль цэцэрлэгт нийгэм сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлнэ.	Багшийн ёс зүйн зөрчлийн тооны бууралт			
	4.2 Хүүхдийн нас, хөгжилд нийцсэн сургууль цэцэрлэгийн орчны стандартыг мөрдүүлж боловсролд тэгш хамрагдах боломжийг бүрдүүлнэ.	Сургуулийн өмнөх боловсролын болон суурь боловсролын хамран сургалтын хувийн өсөлт			
	4.3 Дотуур байрны үйлчилгээний чанарыг сайжруулах “Хүүхдэд ээлтэй дотуур байр” дэд хөтөлбөрийг боловсруулан	Хүүхдэд ээлтэй дотуур байр” дэд хөтөлбөрийн санхүүжилт , зохион			

Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

	хэрэгжүүлнэ	байгуулсан арга хэмжээий тоо			
	4.4 Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг ханган Эко сургууль, цэцэрлэг, байгууллагыг хөгжүүлнэ. Эзэмшил тайлбайн 50-%ийг ногоон бүс болгоно.			Еко сургуулийн сүлжээнд хамрагдсан сургуулийн тоо Ногоон байгууламжийн эзлэх тайлбайн хэмжээ	
	4.5 “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ	Хөтөлбөрийн хэрэгжилт		Дэд хөтөлбөрийн санхүүжилт	
	4.6 Байгууллагын ажилчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулна.	Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлсэн байдал		Байгууллагын материаллаг баазыг бэхжүүлсэн зардлын хэмжээ	
	4.7 Байгууллагын үйл ажиллагааг шилэн болгох	Иргэдийн судалгааны үр дүн Хэвлэн нийтлэсэн ном ,эмхтгэлийн тоо Түгээн дэлгэрүүлсэн ажлын үр дүн  Онлайн сургалтад хамрагдсaдын тоо  Вэб хуудсан дахь хандалтын тоо		Сурталчилгааны зардлын хэмжээ	
Зорилт 5	5.1. Олон угсаатны өв соёлыг өвлүүлэн	Соёл, урлагийн			

Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

	хөгжүүлэх, түгээн дэлгүүлэх “Олон угсаатны өв соёл” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.	салбарын үйлчилгээнд хамрагдагсдын тоо, орлогын хэмжээ			
	5.2. Соёлын ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулах хөтөлбөр хэрэгжүүлж, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Соёлын ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулах сургалтын тоо зарцуулсан санхүүжилт			
	5.3. Үл хөдлөх болон хөдлөх өв соёлын бүтээлийн хадгалалт, хамгааллыг сайжруулж, судалгаа, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Хамгаалалтанд авсан биет болон биет бус өвийн тоо			
	5.4. Хөдөөгийн алслагдсан иргэдэд номын сангийн үйлчилгээг өргөжүүлэх, номын сангуудын үйлчилгээний орчин нөхцлийг сайжруулах “Оюун түлхүүр” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	Урлагийн бүтээлийн тоо, чанар			
	5.5. Номын сангийн үйлчилгээнд дэвшилтэд цахим технологийг нэвтрүүлэх “Цахим номын сан” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ	Цахим номын сангийн мэдээллийн сан бүрдүүлсэн байдал			
Зорилт 6	6.1. Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	Нийлүүлсэн тоног,төхөөрөмжийн тоо, зарцуулсан төсөв Улсын болон орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө,материалаг тусламж дэмжлэг			



Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

	6.2. Санхүүнийг нөөцийн удирдлага, төлөвлөлтийг сайжруулах	Төсөвд үнэлгээ хяналт хийсэн байдал түүнд хамрагдсан байгууллага ,хүний тоо, зарцуулсан төсөв хөрөнгийн хэмжээ			
	6.3. Санхүүгийн ил тод байдлыг бий болгон байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн хяналт, бүтээлч оролцоог нэмэгдүүлнэ.			Төсвийн зарцуулалтын үр дүн	

Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар